



МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ
САЙДЫН ТУШААЛ

2011 оны 02 сарын 01 өдөр

Дугаар 34

Улаанбаатар хот


Тушаалд өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засгийн Газрын 2008 оны 5 дугаар сарын 14-ний өдрийн "Журам батлах тухай" 177 дугаар тогтоолоор батлагдсан "Гадаадын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчдад зээл олгох, эргэн төлүүлэх журам", "Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2007 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 11 дүгээр тушаалаар батлагдсан "Сургалтын төрийн сангийн санхүүжилтээр гадаадад магистрантур, докторантурт суралцах хүмүүсийг шалгаруулах журам"-ыг үндэслэн ТУШААХ НЬ:

1. Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2009 оны 3 дугаар сарын 13-ны өдрийн "Тушаалд өөрчлөлт оруулах тухай" 88 дугаар тушаалын Дорж овогтой Гэрэлтуяатай холбогдолтой хэсгийн "докторантурт" гэснийг "докторантурт 3 жилийн хугацаатайгаар" гэж, 2009 оны 12 дугаар сарын 24-ны өдрийн "Сургалтын төрийн сангийн зээлээр гадаадад суралцуулах тухай" 581 дугаар тушаалын Мэдрээ овогтой Мөнхөөтэй холбогдолтой хэсгийн "University of Bridgeport-ийн урлагийн магистрантурт глобал энх тайван ба хөгжлийн удирдлагын чиглэлээр 0,5 жилийн хугацаатайгаар" гэснийг "Калифорнийн олон улсын их сургуулийн магистрантурт олон улсын бизнесийн чиглэлээр 2 жилийн хугацаатайгаар", 2010 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн "Гадаадад сургалтын төрийн сангийн зээлээр суралцуулах, тушаалд өөрчлөлт оруулах тухай" 568 дугаар тушаалын Ганбаярын Отгонбаяртай холбогдолтой хэсгийн "АНУ-ын /Strayer University/ Стрээр их сургуулийн" гэснийг "Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Шанхайн олон улс судлалын их сургуулийн" гэж тус тус өөрчилсүгэй.

2. Монгол Улсын Засгийн газрын 2008 оны 5 дугаар сарын 14-ний 177 дугаар тогтоолоор батлагдсан "Гадаадын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчдад зээл олгох, эргэн төлүүлэх журам"-ын дагуу суралцагчтай гэрээ байгуулж, холбогдох сургуулийн нэхэмжлэхийн дагуу төлбөр, тооцоо хийхийг Сургалтын төрийн сан /Д.Нансалмаа/-д, энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Мэргэжлийн боловсролын газар /М.Баасанжав/-т тус тус даалгасугай.

САЙД



Е.ОТГОНБАЯР